

ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ
/2015 оны 4-р сарын 22-ноос 2015 оны 5-р сарын 20-ны байдлаар, төгрөгөөр/

№	Барааны нэр, төрөл	IV/22	IV/29	V/06	V/13	V/20
1	Гурил, I зэрэг, кг	1100	1100	1100	1100	1100
2	Хонины мах, кг/ ястай/	7500	7500	7500	7500	7500
3	Үхрийн мах, кг /ястай/	8500	8500	8500	8500	8500
4	Ямааны мах /ястай /	6500	6500	6500	6500	6500
5	Элсэн чихэр, кг	1500	1500	1500	1500	1500
6	Цагаан будаа, кг	2300	2300	2300	2300	2300
7	Шингэн сүү, л	1500	1500	1500	1500	1400
8	Ямааны ноолуурын үнэ 1 кг- цагаан	54000	48000	50000	50000	50000
9	- Бор ноолуур	54000	48000	50000	50000	50000
10	Бензин, А-80, 1 литр	1570	1570	1570	1570	1570
11	Бензин, А-92, 1 литр	1690	1690	1690	1690	1690
12	Дизелийн түлш, 1 литр	1790	1790	1790	1790	1790

Гол нэрийн барааны үнийн 7 хоногийн мэдээгээр аймгийн төвд 2015 оны 4-р сарын 22-ноос 2015 оны 5-р сарын 20-ны хооронд шингэн сүү, ноолуураас бусад бүтээгдэхүүний үнэ тогтвортой байв.

Махны үнэ. Сүүлийн 5 долоо хоногийн турш махны жижиглэн худалдааны үнэ тогтвортой байлаа. Хонины 1 кг ястай мах 7500 төгрөг, үхрийнх 8500 төгрөг, ямааных 6500 төгрөгийн ханштай байна.

Гурил, элсэн чихэр, цагаан будаа. Алтан тариа ХК-ын 1-р гурил, элсэн чихэр, цагаан будааны үнэ сүүлийн 5 долоо хоногийн турш тогтвортой байлаа.

Шингэн сүү. Шингэн сүү 5-р сарын 13-ныг хүртэл 1500 төгрөгийн ханштай байсан ба 5-р сарын 20-нд өмнө долоо хоногийн мөн үеэс 6,7 хувь буюу 100 төгрөгөөр буурч 1400 төгрөг болов.

Ноолуур. Ноолуурын үнэ 4-р сарын 22-нд 54000 төгрөг, 4-р сарын 29-нд өмнөх долоо хоногийн мөн үеэс 11.1 хувиар буурч 48000 төгрөг, 5-р сарын 6-нд өмнөх долоо хоногийн мөн 4.2 хувиар өсч 50000 төгрөг болов. Энэ ханш сүүлийн 3 долоо хоногийн турш хадгалагдаж байна.



